



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/065/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Алтай хот	2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: Gunjidmaaq@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn Аудитор: Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn
---	-----------	---------	---



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Женст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030.
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.24 № 09

танай _____-ны № _____-т

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Ж.МЯНГАНБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс гэрээт ажилтны цалин 25,601.6 мянган төгрөг, хог хаягдлын зардал 480.0 мянган төгрөг, сэлбэг зэсврын зардал 7,293.8 мянган төгрөг, суурин утасны төлбөр 689.6 мянган төгрөгийг зарцуулсан,
- Бараа материалын дансанд 2016-2018 онуудад үйлдлийн систем, ажлын хувцас, гар станц, далдлагч, диктофон, дугаар хураагч, сандал, сейф, гал тогооны шкаф зэрэг 9,740.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн,
- Байгууллагын хөрөнгийг коджуулаагүй, эзэмшигч бүрээр картжуулаагүй, ашиглалт хамгаалалт хангалтгүй, нярвын тайлан гаргаагүй,

.. 822505000273

- Тайлант онд автомашины урсгал засварт 22,805.0 мянган төгрөг, ажилчдын нормын хувцас 8,000.0 мянган төгрөгөөр худалдан авч төсвийг үрэлгэн зарцуулсан,
- Өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтанд 5,149.3 мянган төгрөгийн тэтгэмжийг дутуу тооцож олгосон.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.7, 26 дугаар зүйлийн 26.3 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дэх заалт, "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаал, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2 дахь заалтыг тус тус зөрчсөн нь санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвөөс 1,314,908.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 44,999.8 мянган төгрөг, нийт төсвийг 1,359,907.9 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжилтийг бүрэн авч өөрийн орлого 4,060.9 мянган төгрөгөөр тасарсан байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 15.6 км хатуу хучилттай авто замын трасс дагуух Баянхайрхан, Индэрт, Баяншанд, Түмэн багийн нийт 76 нэгж талбараас 71 нэгж талбарыг бүрэн чөлөөлж дуусгасан байна.

Бусад асуудал

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт 119 арга хэмжээ тусгасанаас 76 арга хэмжээ бүрэн, 16 арга хэмжээ 90.0 хувь, 15 арга хэмжээ 80.0 хувь, 8 арга хэмжээ 70.0 хувь, 3 арга хэмжээ 50.0 хувь, хэрэгжээгүй 1 арга хэмжээ нийт дүнгээр 94.0 хувь үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮДЭХ
АУДИТОР



Г. ҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>892,900,424.63</u>	<u>890,512,904.49</u>
33	АВЛАГА	187,499,326.58	175,315,216.44
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	153,894,723.36	146,567,381.44
335	Бусад авлага	29,320,229.22	28,747,835.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	28,747,835.00	28,747,835.00
35	БАРАА МАТЕРИАЛ	705,401,098.05	715,197,688.05
354	Хангамжийн материал	705,401,098.05	715,197,688.05
35410	Бичиг хэргийн материал	3,204,850.00	469,250.00
35420	Аж ахуйн материал	13,848,280.00	11,772,880.00
35430	Сэлбэг хэрэгсэл	16,137,100.00	26,233,300.00
35470	Бусад хангамжийн материал	672,210,868.05	676,722,258.05
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>474,680,987.04</u>	<u>470,337,971.25</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	474,680,987.04	470,337,971.25
392	Биет хөрөнгө	450,113,903.81	445,954,638.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	356,145,100.00	356,145,100.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(63,014,706.36)	(74,144,240.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	142,800,000.00	142,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(109,550,000.00)	(130,550,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	383,316,751.82	342,729,369.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	(261,985,980.32)	(192,599,441.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,234,518.92	13,546,632.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,831,780.25)	(11,972,782.47)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,830,000.00	630,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,830,000.00)	(630,000.00)
393	Биет бус хөрөнгө	24,567,083.23	24,383,333.20
39301	Программ хангамж	2,060,000.00	980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,712,916.77)	(816,666.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	24,220,000.00	24,220,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,367,581,411.67</u>	<u>1,360,850,875.74</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>6,155,164.45</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	6,155,164.45
413	Өглөг	0.00	6,155,164.45
4136	Бусад өглөг	0.00	6,155,164.45
41361	Байгууллагад төлөх өглөг		6,155,164.45
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,367,581,411.67</u>	<u>1,354,695,711.29</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,367,581,411.67	1,354,695,711.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	183,725,804.35	183,725,804.35
51101	Өмч: - төрийн	183,725,804.35	183,725,804.35
512	Хуримтлагдсан үр дүн	1,183,855,607.32	1,170,969,906.94
51210	Өмнөх үеийн үр дүн	1,183,855,607.32	1,183,855,607.32
51220	Тайлант үеийн үр дүн		(12,885,700.38)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,367,581,411.67</u>	<u>1,360,850,875.74</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,224,158,702.40	1,577,251,067.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,224,158,702.40	258,961,605.18
120	Нийтлэг татварын бус орлого	111,767,954.84	258,961,605.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	111,767,954.84	258,961,605.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		187,506,205.18
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,137,457,282.26	71,455,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,688,977,740.29	1,318,289,462.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,480,629,578.77	1,262,115,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,270,467,600.00	1,262,115,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	208,348,161.52	56,174,462.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		44,148,550.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	208,348,161.52	12,025,912.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,625,848,522.15	1,590,136,767.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,625,848,522.15	1,590,136,767.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,423,966,641.62	1,501,113,450.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	944,903,285.65	1,019,551,007.94
210101	Үндсэн цалин	553,546,600.58	605,829,121.49
210102	Нэмэгдэл	276,396,955.53	259,445,595.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,904,065.64	88,494,860.00
210104	Урамшуулал	36,055,663.90	65,781,430.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,361,529.17	129,285,659.28
210201	Тэтгэврийн даатгал	83,381,417.02	89,113,094.58
210202	Тэтгэмжийн даатгал	9,622,051.80	10,675,774.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,759,325.88	5,034,439.04
210204	Ажилгүйдлийн даатгал	4,505,175.62	4,886,311.72
210205	Эрүүл мэндийн даатгал	18,093,558.85	19,576,039.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,009,881.23	32,458,857.09
210301	Гэрэл, цахилгаан	2,744,376.20	3,409,464.44
210302	Түлш, халаалт	25,297,145.03	26,453,112.65
210303	Цэвэр, бохир ус	3,968,360.00	2,596,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,819,575.52	54,259,794.48
210401	Бичиг хэрэг	469,250.00	9,967,700.00
210402	Тээвэр, шатахуун	21,493,745.52	33,895,234.48
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	118,300.00	1,004,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	738,277.00	3,654,110.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		5,738,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,028,500.00	17,346,173.39
210604	Урсгал засвар	50,028,500.00	17,346,173.39

2107	Томилолт, зочны зардал	98,768,050.00	108,120,000.00
210702	Дотоод албан томилолт	98,768,050.00	108,120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,909,380.00	14,810,111.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,851,300.00	10,729,161.00
210803	Даатгалын үйлчилгээ		1,503,950.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	58,080.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,533,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,166,443.05	125,281,847.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	84,310,624.36	50,394,531.96
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,855,818.69	74,887,315.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	201,881,880.53	89,023,316.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	79,231,000.00	59,406,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	800,000.00	45,281,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	78,431,000.00	14,125,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	129,134,258.67	29,616,816.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,134,258.67	29,616,816.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,598,310,180.25	(12,885,700.38)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,596,878,963.00	(12,885,700.38)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,528,890,971.50	1,513,123,009.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,066,570.00	40,938,824.74
120	Нийтлэг татварын бус орлого	50,066,570.00	40,938,824.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,066,570.00	40,938,824.74
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,066,570.00	40,938,824.74
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,478,824,401.50	1,472,184,185.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,270,467,600.00	1,262,115,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,270,467,600.00	1,262,115,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	208,356,801.50	210,069,185.36
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		44,148,550.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	208,356,801.50	165,920,635.36
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,533,949,201.50	1,513,123,009.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,533,949,201.50	1,513,123,009.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,332,191,821.00	1,424,099,692.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	942,743,485.70	1,012,436,248.94
210101	Үндсэн цалин	551,386,800.60	585,664,016.45

210102	Нэмэгдэл	276,396,955.50	273,436,512.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,904,065.60	88,250,141.24
210104	Урамшуулал	36,055,663.90	65,085,578.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,332,684.20	129,285,659.28
210201	Тэтгэврийн даатгал	82,352,572.10	89,113,094.58
210202	Тэтгэмжийн даатгал	9,622,051.80	10,675,774.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,759,325.90	5,034,439.04
210204	Ажилгүйдлийн даатгал	4,505,175.60	4,886,311.72
210205	Эрүүл мэндийн даатгал	18,093,558.90	19,576,039.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,573,657.20	28,885,692.64
210301	Гэрэл, цахилгаан	2,744,376.20	3,409,464.44
210302	Түлш, халаалт	25,297,145.00	22,879,948.20
210303	Цэвэр, бохир ус	4,532,136.00	2,596,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,225,772.50	39,575,844.48
210401	Бичиг хэрэг	795,450.00	3,055,600.00
210402	Тээвэр, шатахуун	21,493,745.50	33,609,494.48
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	118,300.00	1,022,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	818,277.00	1,888,500.00
2105	Норматив зардал	-	8,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		8,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,028,500.00	28,870,973.39
210604	Урсгал засвар	5,028,500.00	28,870,973.39
2107	Томилолт, зочны зардал	98,768,050.00	108,120,000.00
210702	Дотоод албан томилолт	98,768,050.00	108,120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,531,430.00	15,673,486.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,473,050.00	11,158,536.00
210803	Даатгалын үйлчилгээ		1,503,950.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	58,380.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,967,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,988,241.40	53,251,787.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	96,988,241.40	53,251,787.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	201,757,380.50	89,023,316.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	79,231,000.00	59,406,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	800,000.00	45,281,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	78,431,000.00	14,125,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	122,526,380.50	29,616,816.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	122,526,380.50	29,616,816.63

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	183,725,804.35	1,183,855,607.32	1,367,581,411.67
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	183,725,804.35	1,183,855,607.32	1,367,581,411.67
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	183,725,804.35	1,183,855,607.32	1,367,581,411.67
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	183,725,804.35	1,183,855,607.32	1,367,581,411.67
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	183,725,804.35	1,183,855,607.32	1,367,581,411.67
D08	Тайлант үеийн үр дүн		(12,885,700.38)	(12,885,700.38)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	183,725,804.35	1,170,969,906.94	1,354,695,711.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,359,907,900.0	1,280,612,628.90	79,295,271.10	94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,359,907,900.0	1,280,612,628.9	79,295,271.1	94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,300,501,400.0	1,221,206,128.90	79,295,271.1	94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,089,343,300.0	1,012,436,248.94	76,907,051.1	93
210101	Үндсэн цалин	588,486,400.0	585,664,016.45	2,822,383.5	100
210102	Нэмэгдэл	361,103,500.0	273,436,512.93	87,666,987.1	76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,965,200.0	88,250,141.24	(37,284,941.2)	173
210104	Урамшуулал	88,788,200.0	65,085,578.32	23,702,621.7	73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,021,400.0	129,285,659.54	8,735,740.5	94
210201	Тэтгэврийн даатгал	90,945,700.0	89,113,094.84	1,832,605.2	98
210202	Тэтгэмжийн даатгал	11,768,900.0	10,675,774.06	1,093,125.9	91
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,884,500.0	5,034,439.04	850,061.0	86
210204	Ажилгүйдлийн даатгал	5,884,500.0	4,886,311.72	998,188.3	83
210205	Эрүүл мэндийн даатгал	23,537,800.0	19,576,039.88	3,961,760.1	83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,933,200.0	28,885,692.64	2,047,507.4	93
210301	Гэрэл, цахилгаан	3,889,200.0	3,409,464.44	479,735.6	88

210302	Түлш, халаалт	20,830,700.0	22,879,948.20	(2,049,248.2)	110
210303	Цэвэр, бохир ус	6,213,300.0	2,596,280.00	3,617,020.0	42
2104	Хангамж, бараа материалын зардал	2,143,600.0	936,900.00	1,206,700.0	44
210401	Бичиг хэрэг	1,246,700.0	619,550.00	627,150.0	50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	448,800.0	317,350.00	131,450.0	71
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	448,100.0	-	448,100.0	-
2105	Норматив зардал	118,600.0	-	118,600.0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	118,600.0	-	118,600.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,500.0	36,300.00	1,200.0	97
210604	Урсгал засвар	37,500.0	36,300.00	1,200.0	97
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,151,600.0	11,868,936.00	2,282,664.0	84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,038,300.0	11,158,536.00	1,879,764.0	86
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	666,400.0	-	666,400.0	
210803	Даатгалын үйлчилгээ	140,300.0	666,400.00	(526,100.0)	475
210804	Тээврийн хэрэгслийн татвар	306,600.0	-	306,600.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		44,000.00	(44,000.0)	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,042,200.0	37,046,391.78	(12,004,191.8)	148
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,042,200.0	37,046,391.78	(12,004,191.8)	148
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,359,907,900.0	1,280,612,628.86	79,295,271.1	94
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,314,908,100.0	1,239,673,804.86	75,234,295.1	94
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,314,908,100.0	1,239,673,804.86	75,234,295.1	94
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	44,999,800.0	40,938,824.00	4,060,976.0	91
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,999,800.0	40,938,824.00	4,060,976.0	91

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	210,069,185.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	210,069,185.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	202,893,563.87
2104	Хангамж, бараа материалын зардал	38,638,944.48
210401	Бичиг хэрэг	2,436,050.00

210402	Тээвэр, шатахуун	33,609,494.48
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	704,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,888,500.00
2105	Норматив зардал	8,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,834,673.39
210604	Урсгал засвар	28,834,673.39
2107	Томилолт, зочны зардал	107,410,000.00
210702	Дотоод албан томилолт	107,410,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,804,550.00
210803	Даатгалын үйлчилгээ	837,550.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,967,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,205,396.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,205,396.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,175,621.49
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,175,621.49
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,175,621.49
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	210,069,185.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	210,069,185.36
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,148,550.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	165,920,635.36

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,035,702.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Дээд газраас шилжүүлэн авсан 70,544.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдаж авснаар, хөрөнгийн элэгдлийн зардлыг 7,301.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,

- Төсвийн гүйцэтгэлийг мэдээг, төсвийн хэлбэлзэлтэй тулгахад цалин хөлс нэмэгдэл урамшлын зардал 44,342.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 7,859.6 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 2,436.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 7,797.0 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан,
- Орлогыг 40,655.4 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайлангийн зардлыг 82,192.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг тус тус залрууллаа.

Мэдээллийг орхигдуулсантай холбоотой: Шилэн дансны цахим сайтад байршуулах таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 772,572.2 мянган төгрөгийн 9 мэдээллийн дутуу мэдээлснийг нөхөн байршуулсан.

Залруулагдаагүй нийт 70,684.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 5,814.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 64,870.0 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Албан шаардлага

1. Өндөр насны тэтгэвэрт гарсан 2 ажилтны тэтгэмжийг тооцохдоо 1 ажилтанд 665.4 мянган төгрөгийн илүү, 1 ажилтанд 5,149.3 мянган төгрөгийн тэтгэмжийг дутуу тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгож журам"-ын 3 дугаар зүйл 3.1.12-т "Нийгмийн шилжилтийн явцад ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний 1990-1995 оны хооронд ажилласан жил тасарсан иргэнд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагаас зохих журмын дагуу олгосон баталгаажилтын хуудсыг үндэслэн ажилласнаар нөхөн тооцуулсан хугацаа", 5 дугаар зүйлийн 5.4-д "Төрийн албан хаагчийн ажиллаж байсан байгууллагын дарга, хүний нөөц болон санхүү хариуцсан ажилтнууд энэ журмын дагуу тухайн төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацаа, үндсэн цалинг үнэн зөв тодорхойлох үүрэг хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тэтгэмжийн тооцооллыг дахин хийн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүллээ.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд

Нэг: Бараа материалтай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Бараа материалын тайланд 2016-2018 онуудад үйлдлийн систем, ажлын хувцас, гар станц, далдлагч, диктафон, дугаар хураагч, сандал, сейф, толь, тоос сорогч, гал тогооны шкаф зэрэг 9,740.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна"

Өгсөн зөвлөмж: Бараа материалын бүртгэл хөтлөлт болон үе шатны хяналтыг сайжруулж ажиллах.

Хоёр: Бараа материалтай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тайлант онд нярвын тайлан гаргаагүй, нягтлан бодогч нь тайланг хянаж, баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нярвын тайланг үнэн зөв гаргаж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Гурав: Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Байгууллагын хөрөнгийг код байхгүй, эзэмшигч бүрээр карт байхгүй, ашиглалт хангалтгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж,

байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-т жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг чанартай хийж, ашиглалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авч зөрчлийг арилгах.

Дөрөв: Хууль тогтоомжтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажилчдын нормын хувцас 8,000.0 мянган төгрөгөөр худалдан авч төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвөөс хувцас худалдан авсан зөрчлийг давтан гаргахгүй байх.

Тав: Тайлант онд автомашины урсгал засварт 22,805.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2-т "Автомашины шатахуун зарцуулалтын жишиг норм, шатахуун зарцуулалтын жишиг нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд, автомашин, түүний үндсэн агрегат, зангилаанууд, резин дугуй, зай хураагуурын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм, түүнийг нэмэгдүүлэх болон хорогдуулах нөхцөлүүдийг харгалзан өөрсдийн ажил үйлчилгээнийхээ онцлогт нийцүүлэн мөрдөж ажиллахыг автотээврийн байгууллага, аж ахуйн нэгж, автотээврийн хэрэгсэл бүхий иргэдэд зөвлөсүгэй" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна"

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар нормыг тогтоож, шаардлагатай сэлбэг эд ангийг техникийн комисс томилж, дүгнэлт гаргаж зарцуулах.

Зургаа: Бараа үйлчилгээний бусад зардлаас гэрээт ажилтны цалин 25,601.6 мянган төгрөг, хог хаягдлын зардал 480.0 мянган төгрөг, сэлбэг засварын зардал 7,293.8 мянган төгрөг, суурин утасны төлбөр 689.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна"

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн ангиллыг мөрдөж, цаашид зөрчлийг гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								тоо	Дүн	тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	Шилэн дансны цахим сайтад байршуулах таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 772,572.2 мянган төгрөгийн 9 мэдээллийн аудитын явцад нөхөн тайлагнасан	1	772,572.5	1	772,572.5	-	-	1	772,572.5	-	-
	Дээд газраас шилжүүлэн авсан 70,544.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдаж авснаар, хөрөнгийн элэгдлийн зардлыг 7,301.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	77,846.1	-	-	1	77,846.1	1	77,846.1	-	-
	Төсвийн гүйцэтгэлийг мэдээг, төсвийн хэлбэлзэлтэй тулгахад цалин хөлс нэмэгдэл урамшлын зардал 44,342.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 7,859.6 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 2,436.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 7,797.0 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлснийг залруулав	1	62,435.1	-	-	1	62,435.1	1	62,435.1	-	-
	Орлогыг 40,655.4 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайлангийн зардлыг 82,192.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	122,847.9	-	-	1	122,847.9	1	122,847.9	-	-
Дүн		4	1,035,702.0	1	772,572.5	3	263,129.1	4	1,035,702.0	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:						
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	Бараа материалын тайланд 2016-2018 онуудад үүргэвч, үйлдлийн систем, ажлын хувцас, ажлын хавтас, гар станц, далдлагч, диктофон, дугаар хураагч, нууцын тэмдэг, сандал, сейф, толь, тоос сорогч, печ, гал тогооны шкаф зэрэг 9,740.8 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэн байна.	1	-	-	-	-	-	1	-	
	Биет тооллого хийхэд хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй, хөрөнгийг коджуулах, эзэмшигч бүрээр картжуулаагүй, нягтлан бодогч солигдсон боловч тооллого хийгдээгүй байна.	1	-	-	-	-	-	-	1	-
	Тайлант онд автомашины урсгал засварт 22,805.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	22,805.0	-	-	-	-	-	1	22,805.0
	Ажилчдын нормын хувцас 8,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.	1	8,000.0	-	-	-	-	-	1	8,000.0
	Өндөр насны тэтгэвэрт гарсан 2 ажилтны тэтгэмжийг тооцохдоо 1 ажилтанд 665.4 мянган төгрөгийн илүү, 1 ажилтанд 5,149.3 мянган төгрөгийн тэтгэмжийг дутуу тооцож олгосон байна.	1	5,814.8	-	-	1	5,814.8	-	-	
	Няrvын тайлан гаргаагүй, нягтлан бодогч нь тайлан хянаагүй, орлого нь тодорхойгүй, санхүүгийн программаас тайланг хэвлэсэн, аудитаар түүвэрчлэн бичгийн цаасны зарлагыг тулгаж үзэхэд нягтлан бодох бүртгэлээс 11-ээр илүү шаардах хуудас бичс-эн байна.	1	-	-	-	-	-	-	1	-
	Бараа үйлчилгээний бусад зардал буюу /210901/ зардлын ангиллаас гэрээтийн цалин 25,601.6 мянган төгрөг, хог хаягдлын зардал 480.0 мянган төгрөг, сэлбэг засврын зардал 7,293.8 мянган төгрөг, суурин утасны төлбөр 689.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	1	34,065.0	-	-	-	-	-	1	34,065.0
Дүн		7	70,684.8			1	5,814.8	6	64,870.0	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		